

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН ҮЙЛДВЭРИЙН
БҮСЭД БАЙРЛАХ

“НЭХИЙ ТАННЕРИ” ХХК-ИЙН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “ДАРХАН
АРЬС ШИР БОЛОВСРУУЛАХ ЦОГЦОЛБОР ҮЙЛДВЭР”
ТӨСЛИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Агуулга

1	ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	2
1.1	Төслийн ерөнхий мэдээлэл	2
	Төслийн нэр:.....	2
	Төсөл хэрэгжүүлэгч:	2
1.1.1	Төслийн талбайн байршил, хэрэгжиж буй орчны тойм зураг	2
1.2	Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга	2
1.3	Үйл ажиллагаа.....	3
1.4	Дэд бүтэц	3
1.5	Хог хаягдлын менежмент.....	3
1.5.1	Хатуу хог хаягдал	4
1.5.2	Химийн бодисын хог хаягдал	4
2	ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	5
2.1	Газарзүйн байршил	5
2.2	Уур амьсгал	5
2.3	усан орчин.....	6
2.4	Хөрсөн бүрхэвч	7
2.5	Ургамлан нөмрөг	7
2.6	Амьтны аймаг	7
2.7	Тусгай хамгаалалттай газар нутаг	7
2.8	Түүх соёлын өв.....	8
2.9	Нийгэм, эдийн засаг	8
2.10	Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт.....	8
3	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ	10
3.1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй	10
3.1.1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	11
3.1.2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	15
3.1.3	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	15
3.1.4	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	16
3.1.5	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	17
3.1.6	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	20
3.1.7	Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ	22
3.1.8	2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	24

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 2-1. Нөлөөллийн үнэлгээ.....	8
Хүснэгт 3-1 БОМТ-г хэрэгжүүлэх зардал, 2025 он.....	10
Хүснэгт 3-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	11
Хүснэгт 3-3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө.....	15
Хүснэгт 3-4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	16
Хүснэгт 3-5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	19
Хүснэгт 3-6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	20
Хүснэгт 3-7 Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ.....	22
Хүснэгт 3-8. БОМТ-ний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь	24

1 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1 ТӨСЛИЙН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр: “Дархан арьс шир боловсруулах цогцолбор үйлдвэр”


Төсөл хэрэгжүүлэгч: “Нэхий таннери” ХХК

- Улсын бүртгэлийн дугаар: 1911024140
- Регистрийн дугаар: 4280288
- Хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум, 13-р баг
- Утас: +976 70378499

1.1.1 Төслийн талбайн байршил, хэрэгжиж буй орчны тойм зураг

Үйлдвэрийн байр нь Дархан-Уул аймгийн Дархан сумын 13-р баг, үйлдвэрийн бүсэд байрлах ба 8.9 га талбайтай, 21737 м² бүхий цутгамал бетон карказан барилгад үйл ажиллагаа явуулдаг.

Төслийн талбайн байршлын зургийг Зураг 1-1-т харууллаа.



Зураг 1-1. Үйлдвэрийн талбайн байршил

1.2 ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧИЙН ТАНИЛЦУУЛГА

Нэхий таннери ХХК нь Дархан Нэхий ХК-ийн охин компани бөгөөд арьс шир боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Тус компани нь түүхий эдээс эхлэн нойтон болон хуурай боловсруулалт хийж, хагас боловсруулсан арьс үйлдвэрлэн оёдлын охин компаниуд болон дотооддоо борлуулалт хийдэг. 2013 оноос механикийн боловсруулалт хийж бэлэн боловсруулсан арьс үйлдвэрлэн ажиллаж байна.

Нэхий боловсруулах үйлдвэр нь 2018 оны 11 дүгээр сараас Нэхий таннери ХХК болж бүтцийн өөрчлөлт хийж Евро стандартад нийцсэн байгальд ээлтэй, эко технологиор бүтээгдэхүүн үйлдвэрлэл явуулдаг бөгөөд экологийн шаардлага хангасан дээд зэргийн чанартай бүтээгдэхүүн

болох хонины нэхий, ямааны арьс, үхэр сарлагийн шир, ноос зэргийг боловсруулж зах зээлд худалдаалж байна.

2020 оноос Бид нийт хэрэглэгчдийнхээ сэтгэл ханамжийг тогтмол өндөр байлгах зорилгоор чанарын удирдлагын тогтолцооны ISO9001:2015 олон улсын стандартыг үйлдвэртээ нэвтрүүлсэн нь хэрэглэгч харилцагчдынхаа итгэлийг улам баталгаажуулж байгаагийн нэг илрэл болсон.

1.3 ҮЙЛ АЖИЛЛАГАА

Үйлдвэр нь өдөрт 1500 ширхэг хонины арьс, 500 ширхэг үхрийн шир боловсруулах хүчин чадалтай.

Нэхий таннери ХХК нь

- Нэхий боловсруулах үйлдвэр
- Шир савхи боловсруулах үйлдвэр гэсэн 2 үндсэн чиглэлээр үйлдвэрлэл явуулж байна.

Нэхий боловсруулах үйлдвэр нь түүхий эдийн 105-р тасаг, нойтон боловсруулах 110-р тасаг, гүйцээн боловсруулах 160, 180-р тасгаас бүрдэнэ.

Шир, савхи боловсруулах үйлдвэр нь түүхий эдийн 106-р тасаг, нойтон боловсруулах 111-р тасаг, гүйцээн боловсруулах 161, 181-р тасагтай. Мөн удирдлагын баг буюу ИТА, засвар үйлчилгээний баг буюу ТНА гэсэн бүтэцтэй нийт 100 гаруй ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Нийт ажилтнуудын 18-24 насны ажилтан 10.8%, 25-30 нас 22.9%, 31-36 нас 33.7%, 37-43 нас 9.6%, 44-50 нас 13.3%, 51-55 нас 4.8%, 56-аас дээш насны ажилтан 4.8%-г тус тус эзэлж байна.

1.4 ДЭД БҮТЭЦ

Дулаан, эрчим хүчний хангамж

Үйлдвэрийн байгууламжийн дулаан, эрчим хүчний хангамжийг Дархан-Уул аймгийн Дархан сумын төвлөрсөн хангамжаас “Дархан дулааны сүлжээ” ТӨХК –тай гэрээ байгуулж ханган ажилладаг. Эрчим хүчний хувьд газраар дамжуулан 6 вольт хүчдэлтэй 2 талын тэжээлтэй шугамаар цахилгаан эрчим хүч авахаас гадна өөрийн дэд станцтай юм.

Усан хангамж

Нэхий таннери ХХК нь “Цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх аж ахуйн гэрээ”-г “Дархан-Ус суваг” ХК-тай байгуулан ус хангамжийг шийдэж ажилладаг.

1.5 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТ

Хог хаягдлын тухай хууль нь 2012 оны 5-р сарын 17-ны өдөр батлагдсан бөгөөд 2017 он шинэчлэн баталсан. Хог хаягдлын тухай хуулиар хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, устгах, экспортлох болон хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахыг заасан. Мөн энэ хуулиар агаар мандал, усан орчны болон цацраг идэвхт хог хаягдлаас бусад хог хаягдалтай холбогдсон харилцааг зохицуулна. Хог хаягдлын тухай хуульд аж ахуйн нэгж байгууллага нь:

- I. Хог хаягдлыг дахин боловсруулах арга технологийг нэвтрүүлэх;
- II. Үйлдвэрлэл, үйлчилгээний төрлөөс хамаарч хог хаягдлыг төрөлжүүлж, хог хаягдал хадгалах түр цэгт ангилан хаях, хог хаягдлын талаарх мэдээллийг төрийн болон нутгийн захиргааны байгууллагад үнэн зөв мэдээлэх;
- III. Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх авсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан биелэлтийг хангаж ажиллах;
- IV. Аюултай хог хаягдлыг аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж, эсхүл тогтоосон тусгай цэгт устгах ёстой талаар заажээ.

1.5.1 Хатуу хог хаягдал

Ажилчдын ахуйн хэрэглээ болон үйлдвэрээс гарсан хатуу хог хаягдлыг зориулалтын хогийн савуудад хадгалан хог хаягдлын гэрээний дагуу дуудлага өгч нэгдсэн цэгт зайлуулдаг.

1.5.2 Химийн бодисын хог хаягдал

Хог хаягдлын тухай хуульд “аюултай хог хаягдал” гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдал гэж заасан байна.

Үйл ажиллагаанаас гарах химийн бодисын хог хаягдал /өнгөт металл тоног төхөөрөмжийн өнгөлөгч будгийн сав, баглаа боодол болон даралтат хоосон сав, г.м /-ыг Хог хаягдлын тухай хуулийн 23 дугаар зүйлд зааснаар Аюултай хог хаягдлыг эх үүсвэр дээр түр хадгалан, устгах, дахин ашиглах эрх бүхий мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан ажиллаж байна.

2 ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1 ГАЗАРЗҮЙН БАЙРШИЛ

Дархан-Уул аймаг орчмын нутаг нь хөрс газарзүйн мужлалаар био-уур амьсгалын Хангайн мужийн холимог бүсшил бүхий Орхон-Туулын дэд мужийн 14 дүгээр тойрогт багтана. Энэ тойрогт хархүрэн, нимгэн хүрэн, нугын хүрэн, уулын ширэгт тайгын хөрс, Хараа голын татмаар аллювийн ширэгт хөрс тархана.

Дархан-Уул аймаг нь Хараа голын савын зүүн талд, нам ухаа гүвээрхэг, талархаг газар д.т.д 700-850м орчим өндрийн түвшинд байрлана. Хэнтийн нурууны баруун хойд хэсэгт Хараа, Шарын голын хооронд орших Цайдмын нурууны баруун урд талын дундаж нам уулсын толгод гүвээрхэг ландшафт, уулс хоорондын өргөн хөндийнүүдтэй. Энэ орчмын хамгийн өндөр уулс нь Углуу (1314м), Цогт өндөр (1214м) юм. Тэгш тал, гүвээрхэг хажуу гадарга нь Хараа, Шарын гол, Баянголын хөндийнүүдтэй нийлдэг. Дархан хотын орчимд Хараа голын хөндий 3км орчим өргөн байх бөгөөд Орхон голтой нийлэх үедээ 8-10 км өргөн болдог байна

2.2 УУР АМЬСГАЛ

Байгалийн эрс тэс уур амьсгалтай, жилийн 4 улирлын ялгаа ихтэй, агаарын температурын хэлбэлзэл их, хур тунадасны хэмжээ, чийг багатай цаг агаарын нөхцөлтэй. Тус аймаг нь уур амьсгалын мужлалын хувьд ширүүвтэр өвөлтэй, дулаан зунтай, чийгээр дутмаг мужид багтана.

Нарны цацраг: Тухайн нутгийн газар зүйн болон гадаргын байрлал, өндөр, өргөрөг, үүлшил, цаг агаарын үзэгдэл зэргээс хамааран нарны гийлүүлэл, нарны цацрагийн хэмжээ харилцан адилгүй хуваарилалттай. Дархан-Уул аймгийн нутагт жилд дунджаар 2177-2793 орчим цаг нар гийгүүлдэг бөгөөд нарны гийгүүллийн хоногийн дундаж хугацаа зун 9-10.5 цаг, өвөл 3.5-6.5 цаг, хавар, намрын улиралд 6-8 цаг байдаг. Фотосинтезийн идэвхт цацраг 153.7-239.4 мДж/см² байдаг.

Агаарын даралт: Станцын түвшин дэх агаарын даралтын сарын дундаж утга 922.9-940.1 г/Па, хамгийн их даралт нь 957.6- 965.8 г/Па, хамгийн бага нь 818.1-913.0 г/Па хооронд хэлбэлздэг.

Агаарын температур: Дархан-Уул аймаг орчмын нутгаар сүүлийн 30 жилийн хугацаанд агаарын температурын жилийн дундаж -1.9 градус хүйтнээс +3.2 градус дулаан байдаг байна. 1984-1988,1991,1996, 2005, 2010, 2012 онуудад агаарын температурын жилийн дундаж утга хасаж градустай, бусад онуудад нэмэх градустай байдаг.

Агаарын температурын УАД-нь 0.7 градус дулаан, хамгийн их нь 1999 онд 44.5 градус /Хонгор суманд 7 сард / хүрч халсан, хамгийн бага нь 2001 онд -48.5 градус /Хонгор суманд 1 сард / хүрч хүйтэрсэн байна. Жилд дунджаар 220-230 өдөр хүйтрэлтэй байж бусад хугацаанд дулаан байдаг. УАД-аар хаврын эцсийн цочир хүйтрэл агаарт 5 дугаар сарын III-10 хоногт, намрын эхний цочир хүйтрэл 9 дүгээр сарын II-10 хоногт ажиглагддаг.

Хөрсний температур: Дархан-Уул аймгийн хөрсний гадаргын температурын УАД 3.1 градус дулаан, хамгийн их нь 2010 онд 71,2 градус /Шарын гол суманд 7 сард/ хүрч халсан, хамгийн бага нь 1999 онд - 49.2 градус /Дархан суманд 1 сард/ хүрч хүйтэрч байсан.

Хөлдөлтийн гүн жил бүр харилцан адилгүй байдаг ба дунджаар 260 см хүрч хөлддөг. УАД-аар 11 дүгээр сарын I-10 хоногт хөрс хөлдөж эхэлдэг бөгөөд 2 дугаар сарын I-10 хоногт бүрэн хөлдөж дуусдаг. Хавар 3 дугаар сарын III-10 хоногоос хөрсний өнгөн үе гэсэж, 4 дүгээр сарын II-10 хоногоос 5 дугаар сарын II-10 хоногийн хооронд хөрс бүрэн гэсэж дуусдаг.

Хур тунадас: Аймгийн нийт нутгаар жилд дунджаар 330.7 мм хур тунадас унадаг бөгөөд хур тунадасны 90% нь дулааны улиралд, 10% нь хүйтний улиралд ордог байна. Хур тунадасны 30 жилийн нормоос харахад хамгийн их нь 1985 онд 472,4 мм тунадас, хамгийн бага нь 1986 онд 195.6 мм тунадас унаж байжээ.

Тус аймагт 1985, 1990, 1994 онуудад харьцангуй их нь тунадас унаж байсан ба 1985 онд Дархан суманд 472,4 мм, Орхон суманд 407.3 мм, Хонгор суманд 354 мм, 1990 онд Дархан суманд 410.9 мм, 1994 онд Хонгор суманд 417.0 мм, Орхонд 372.1 мм тунадас оржээ.

Агаарын чийгшил: Агаарын үнэмлэхүй чийгшил /усны уурын даралтын хэмжээ/ дунджаар 4.3-6.8 мб байдаг. Түүний жилийн явц нь агаарын температурын хэлбэлзэлтэй адил явцтай байна. Хамгийн бага утга нь 1 дүгээр сард 0.5-1.8 мб, хамгийн их нь 7 дугаар сард 9.3-16.7 мб байдаг.

Агаарын дутагдал чийгшил дунджаар 4.8 мб, хамгийн их нь 6 дугаар сард 11.1 мб, хамгийн бага нь 1 дүгээр сард 0.1 мб байна. Агаарын харьцангуй чийгшил дунджаар 68-79% байдаг. Хаврын улиралд /4,5 дугаар сард/ шилжин ирж буй агаарын урсгал хуурай, салхины хүч их зэргээс шалтгаалан харьцангуй чийгшил бага байна. Харьцангуй чийгшлийн хоногийн явц нилээд хэлбэлзэлтэй байдаг ба хамгийн бага нь 13-14 цагийн орчим, хамгийн их нь 4-6 цагийн орчим ажиглагдана.

Салхины горим: Салхины горим нь агаар мандлын орчил урсгал, тухайн орон нутгийн дулааны баланс, уул зүйн онцлогоос шалтгаална. Судалгааны хугацаанд салхины зонхилох чиглэл нь өмнө ба хойд зүгээс, хурдны дундаж 3.4 м/сек байдаг. Салхины үнэмлэхүй их хурд хүйтний улиралд олон жилийн дунджаар 20-23 м/сек, дулааны улиралд 25-32 м/сек хүрдэг.

Хүчтэй салхи: Хүчтэй салхи, шороон шуурга нь эдийн засагт ихээхэн хор хохирол үзүүлдэг аюултай болон гамшигт үзэгдлийн нэг юм. Сүүлийн жилүүдэд хүчтэй салхины тохиолдлын тоо буурах хандлагатай байгаа боловч энэ нь жил жил өөр өөр байх ба ялангуяа хүчтэй аадар борооны өмнө болон аадар бороотой давхцан ажиглагдан түүний учруулсан хохирлын хэмжээ өсөх хандлагатай байна. Хүчтэй салхи манай аймгийн хувьд жилд дунджаар 2-3 удаа ажиглагддаг.

Шороон шуурга: Шороон шуурга нь салхины хурд, газрын гадаргын байдал, хөрсний элэгдэл зэргээс их хамаардаг. Шороон шуурганы улмаас газрын гадаргад их хэмжээний элс зөөгдөн ирж зам харгуйг дарах, хөрсний элэгдлийг бий болгох нөхцөл нь болж байна.

Манай аймагт жилд дунджаар 7-8 өдөр шороон шуургатай байдаг бөгөөд энэ нь гол төлөв хавар 3-5 дугаар сард ажиглагддаг. Сүүлийн жилүүдэд хүчтэй салхитай өдрийн тоо буурч байгаа боловч шороон шуургатай өдрийн тоо нилээд нэмэгдэх хандлагатай байна. Энэ нь хөрсний элэгдэл, элс, шорооны зөөгдлөөс хамаарч салхины хурд нэмэгдэх төдийд их хэмжээний тоос шороо босож алсын барааг муутгаж байгаа нь хүний хүчин зүйл, хот суурины хэт төвлөрлөөс их хамаарч байна.

Манай аймгийн хэмжээнд 2004 онд хамгийн олон буюу 21 өдөр шороон шуургатай байсан бол 1997 онд хамгийн бага 4 өдөр шороон шуургатай байсан

Цасан шуурга: Дархан-Уул аймагт УАД-аар 14 удаа цасан шуурга ажиглагдсан. Цасан шуургатай өдөр нэмэгдэж байгаа нь хаврын улиралд агаарын температурын хэлбэлзэл ихтэй байдгаас зарим жил 5 дугаар сард цас орж цасан шуурга шуурч байсан байна.

2.3 УСАН ОРЧИН

Үйлдвэрийн талбайд хамгийн ойр орших гадаргын усны сан бүхий газар Хараа гол 500м-т урсах бөгөөд голуудын ай савын хувьд Хараа голын ай савд багтана. Хараа голын сав газар нь монгол орны төвийн бүсийн хойд хэсэгт орших бөгөөд Хойд мөсөн далайн ай савд багтана. Хараа гол нь хүн ам ихтэй Дархан-Уул аймгийн усан хангамжийн хэрэглээнд шууд ба дам байдлаар эх үүсвэр болдог. Энэ нь голын усыг шууд хэрэглэхийн зэрэгцээ голын ус нь цэвэр усны үндсэн эх үүсвэрүүд болох гүний худгуудтай гидравлик холбоотой учраас тэдгээрийг тэжээгч орчин болж өгдөг зэрэг олон талын ач холбогдлыг агуулна. Ийм учраас Дархан-Уул аймгийн үйлдвэрлэлийн аливаа процесс, усны хэрэглээтэй энэ голын нөхцөл байдлыг холбон үзэх зайлшгүй шаардлага гарч байна. Хараа голын сав газрын хувьд газрын доорх усны 182сая м³/жил ашиглалтын баримжаат нөөцтэй.

Дархан-Уул аймгийн гадаргын усны химийн шинжилгээний дүнгээр бохирдлын гол үзүүлэлтүүдийг гадаргын усны чанарын MNS4586:98 стандарттай харьцуулахад бохирдлын үзүүлэлтүүд стандартаас давсан тохиолдолгүй.

Хараа голын усны эрдэсжилт 306.1-324.8 мг/л, жинлэгдэх бодис 1.0-2.4 мг/л, хатуулаг 2.74-2.77 мг-экв/л, цахилгаан дамжуулах чадвар 353.0-360.0 мS/cm, төмөр дээд цэгт илрээгүй, доод цэгт 0.01 мг/л, нитратын азот 0.52-0.62 мг/л, кальци 33.5-36.1 мг/л, магни 11.8-13.0 мг/л, цахиур 4.9 мг/л, сульфат 35.9-41.2 мг/л, хлор 5.0-7.8 мг/л, гидрокарбонат 187.9-191.6 мг/л, натри кали 30.8-36.3 мг/л, нийт азотын агууламж 0.533-0.634 мг/л байна.

Хаягдал усны хяналт-шинжилгээ: 2023 оны 02 дугаар сарын 08-нд Дархан сумын Төв цэвэрлэх байгууламжийн орж байгаа болон цэвэршүүлээд гарч байгаа хаягдал бохир усны дээжид хийсэн шинжилгээний дүнг MNS4943:2015 “Хаягдал ус”-ны стандартад заагдсан хүрээлэн байгаа орчинд нийлүүлэх хаягдал усан дахь бохирдуулах бодисын ЗДХ-тэй харьцууллаа. Дархан сумын төв ЦБ-85.0% ба өмнөх сараас 4.1%-иар буурсан байна. Цэвэршүүлээд гарч байгаа усан дахь Ж/б-жинлэгдэх бодисын агууламж 1.2, БХХ5-биохимийн хэрэгцээт хүчилтөрөгчийн агууламж 2.3, нийт азотын агууламж 1.8 дахин давсан бохирдолтой усыг Хараа голд нийлүүлсэн.

2.4 ХӨРСӨН БҮРХЭВЧ

Аймгийн хөрс ургамлын бүрхэвч олон янз байх бөгөөд элсэнцэр, хөнгөн шавранцар хүрэн хөрс зонхилно. Хараа, Шарын голын хөндийгөөр хөрсний бүтэц үржил шимийн хувьд газар тариалан, малын бэлчээрт тохиромжтой.

2.5 УРГАМЛАН НӨМРӨГ

Аймгийн хэмжээгээр ойн сангийн нийт талбайн 96.4% буюу 76135 га-г ойн талбай, 3.6 % буюу 2877 га-г ойн бус талбай эзэлдэг бөгөөд ойн сангийн 72.8 хувийг хус, 23.7 хувийг нарс эзэлж байна.

Ойт хээрийн ургамалжилтын бүслүүрт хамаарагдах бөгөөд хялгана-алаг өвст бүлгэмдэл зонхилжээ. Төслийн талбайд хийсэн хээрийн судалгааны явцад 12 овгийн, 22 төрөлд багтах, 26 зүйлийн ургамлыг бүртгэн тэмдэглэв. Төслийн талбайд ургамлан нөмрөгийн тусгагийн бүрхэц 70-75 %, хайрга чулуун бүрхэвч 3-5 %, хагдан бүрхэвч 3-5 %, ургамал бүрхэвчгүй ил газар 20-25 % орчим байна.

2.6 АМЬТНЫ АЙМАГ

Аймгийн нутагт 400 орчим зүйлийн шувуу, 4 зүйлийн гүрвэл, хоёр нутагтан, 50 гаруй зүйлийн загас, 5 зүйлийн туурайтан, 30 гаруй зүйлийн мэрэгчид, 10 гаруй зүйлийн махан идэштэн, 2 зүйлийн гар далавчтан 12 зүйлийн нялцгай биетэн, 12000 зүйлийн шавж багтдаг. Банников (1954)-ын амьтны аймгийн газарзүйн мужлалаар Дархан-Сэлэнгийн районы ихэнх нутаг “Монгол - Дагуурын хээр” - т, нутгийн зүүн өмнөд багахан хэсэг (Шарын гол орчим) “Хэнтийн уулархаг муж” – ийн тойрогт хамаардаг.

Хараа голын эрэг, голын нуга, УГТСЭШХ (Ургамал газар тариалан, судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн)-ийн генофонд, түршлагын талбай, мод үржүүлгийн газар зэрэг хашаалсан зохиомол экосистемээс гадна, голын сав дагуу элсэн карьерууд, хар ус, төмөр замын дагуу хашаа юм. Дархан хотын хувьд эдгээр орчин нь жижиг хөхтөн амьтан төдийгүй, шувуудын орогнох үлдэгдэл орчин болоод байна.

2.7 ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ ГАЗАР НУТАГ

Дархан-Уул аймгийн нутаг дэвсгэрт Улсын тусгай хамгаалалтад авсан газар нутаг одоогоор бүртгэгдээгүй байна. Харин орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг нийт 32 газрыг бүртгэн авчээ.

2.8 ТҮҮХ СОЁЛЫН ӨВ

Дархан-Уул аймгийн нутагт ажиллаж нийт 19 дурсгалт газрын 148 нэгж ширхэг дурсгалыг давтан болон шинээр олж бүртгэн, тэдгээрийг 861 дижитал гэрэл зураг, 36 ширхэг негатив хальсны зураг, 50 орчим минутын дүрс бичлэгээр тус тус баримтжуулсан байдаг.

2.9 НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ

2022 оны жилийн эцсийн байдлаар аймгийн суурин хүн амын тоо 104551 болж өнгөрсөн оноос 0.2%-иар буурсан байна. Аймгийн хэмжээнд ерөнхий боловсролын 26 сургуульд 24.5 мянган хүүхэд суралцаж, 1163 багш ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд 545 хүүхэд амьдарч байна. 40 цэцэрлэгийн 279 бүлэгт 7.9 мянган хүүхэд хүмүүжиж, 667 үндсэн болон туслах багш ажиллаж байна.

2022 онд аймгийн нэгдсэн эмнэлэг болон сумдын эмнэлгүүдэд амбулаториор 697.2 мянган хүнд үзлэг хийсэн байна. Нийт халдварт өвчлөлийн 15.9 хувийг бэлгийн замын халдварт өвчин, 4.5 хувийг шинэ сүрьеэ, 68.7 хувийг коронавирус, үлдсэн 10.9 хувийг бусад өвчнүүд эзэлж байна. Өнгөрсөн оны мөн үед 13228 хүн халдварт өвчнөөр өвчилж байсан бол энэ онд 2404 болж 10824 тохиолдлоор буурсан байна.

2022 онд Орон нутгийн төсвийн орлого 58.2 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 65.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч 11.9 хувь буюу 6.9 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна. Төвлөрсөн төсвийн орлого 15.9 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 16.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч 3.2 хувь буюу 501.6 сая төгрөгөөр төлөвлөгөө давсан байна.

Аймгийн төсвийн нийт зарлага 68.8 тэрбум төгрөг төлөвлөгдсөнөөс 60.3 тэрбум төгрөгийн санхүүжилт хийсэн байна.

2.10 ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Нэхий таннери ХХК-ийн “Дархан арьс шир боловсруулах цогцолбор үйлдвэр” төслийн БОННУ-ээр төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлсон байна.

Хүснэгт 2-1. Нөлөөллийн үнэлгээ

Байгаль орчны үзүүлэлтүүд	Нөлөөлөх байдал		Хугацаа		Чиглэл			Эрчим		
	Шууд	Шууд бус	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Өөрөө зохицуулагдах	Бага	Дунд	Хүчтэй
Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Гадаргын усны урсцын өөрчлөлт										
Гадаргын усны чанарын өөрчлөлт		x		x		x		x		
Ой, ургамлын бүтцийн өөрчлөлт	x			x			x	x		
Хөрсний элэгдэл, эвдрэл	x			x		x			x	
Геологийн тогтцын өөрчлөлт		x	x					x		
Зэрлэг амьтдын оронзайн өөрчлөлт	x			x				x		
Уур амьсгалын /бичил/ өөрчлөлт	x			x		x			x	
Байгалийн нөөц ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг	x			x		x		x		
Бэлчээр, тэжээлийн байдал	x			x			x	x		
Эрдэс түүхий эдийн нөөц /ус/		x		x			x	x		
Эрчим хүчний нөөц	x			x		x		x		

Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ	x			x		x		x		
Урсгал усны нөөцийн горим										
Агаарын бохирдол	x			x		x		x		
Хөрсний, бохирдол элэгдэл	x			x			x		x	
Хорт бодис хүн, амьтанд нөлөөлөх	x			x		x				x
Дуу чимээний нөлөөлөл	x			x				x		
Нийгэмд үзүүлэх нөлөөлөл										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	+			+		+		+		
Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх		+		+		+		+		
Хүн амын орлого өөрчлөгдөх	+			+		+		+		
Хүн амын эрүүл мэнд, соёл	+			+	+			+		
Эдийн засаг, нийгмийн асуудал										
Татварын орлого өөрчлөгдөх	+			+	+			+		
Орон нутгийн орлог өөрчлөгдөх	+			+		+		+		
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+			+		+		+		
Ажлын байр нэмэгдэх	+			+		+		+		
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+		+					+		
Бусад нөлөөлөл										
Ахуйн бохир уснаас хөрс, газрын доорх ус бохирдох	x		x				x	x		
Химийн бодис асгарах, алдагдах	x			x	x				x	
Галын аюулгүй алдагдах	x		x		x					x
Дүн	23	4	4	23	4	14	5	21	6	2

Тайлбар: “x” сөрөг нөлөөлөл, “+” эерэг нөлөөлөл

Хүснэгтээс үзвэл байгаль орчин, нийгэм эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөллийн нийт тоо 27 байна. Нөлөөллийн байдлыг доор үзүүлэв. Үүнд:

Шууд нөлөөлөл. Энд болзошгүй нөлөөллийн ихэнх нь шууд нөлөөлөлд хамрагдаж байна. Төслийн явцад тодорхой хэмжээгээр хөрсний эвдрэл гарах, үүний улмаас ургамлын бүтцийн өөрчлөлт гарч болзошгүйгээс гадна ундны усны чанар, хэмжээ болон агаарын чанарт бага зэргийн сөрөл нөлөө үзүүлэх талтай.

Шууд бус нөлөөлөл. Хүн болон техникийн хөдөлгөөн ихсэх, эзэмшил газрын гадаргын тогтоц өөрчлөгдөн хотгор гүдгэрийн сөрөг хэлбэрүүд үүсэх, хог хаягдлыг удаан хугацаагаар хадгалах болон автомашины төвлөрлөөс шалтгаалан агаар, хөрс бохирдох нөлөөлөл зэрэг нь шууд бус сөрөг нөлөөлөлд хамаарч байна.

Богино хугацааны нөлөөлөл. Үүнд зөвхөн төслийн үйл ажиллагаанаас болон барилга, байгууламж нэмж барих тохиолдолд өнгөн хөрсний бохирдол ба эвдрэл, агаарын бохирдол түр зуур гарах зэрэг нөлөөлөл хамаарна.

Урт хугацааны нөлөөлөл. Төслийн үйл ажиллагаа удаан хугацаагаар үргэлжлэх учир байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн ихэнх /85.2%/ нь урт хугацаанд экологийн тогтолцоонд бүгд буцалтгүй нөлөөлөхөөр байна. Үүнд үйл ажиллагааны улмаас орчны, гадаргын хэлбэр, ургамлын бүрхэц, бичил уур амьсгал өөрчлөгдөх эрчим хүчний хэрэглээний өсөлт гарах, дуу чимээ нэмэгдэх зэрэг сөрөг нөлөөллүүдээс гадна, орон нутгийн эдийн засагт үзүүлэх эерэг нөлөөллүүд хамаарч байна.

Нөлөөллийн эрчим. Төслийн нийт нөлөөллийг эрчимшлээр нь авч үзвэл, 72.4% нь сул болон сулавтар, 20.7% нь дунд зэрэг, 6.9% нь их зэрэгт багтах нөлөөлөл байна. Нийт нөлөөллийн 17 нь сөрөг байхаар байна.

3 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Зорилго, зорилт: Нэхий таннери ХХК-ийн Дархан арьс шир боловсруулах цогцолбор үйлдвэр төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол Улсын “Байгаль орчныг хамгаалах тухай” болон “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” хуулиуд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29–ний өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” зэргийг мөрдлөг болгон боловсруулсан бөгөөд энэ төлөвлөгөөнд тусгагдсан үүрэг даалгавруудыг биелүүлэхийг гол зорилго болгосон.

Баримтлах зарчим: Төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 11 сарын 1-ний дотор Дархан сумын ЗДТГ-т танилцуулан, Дархан-Уул аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт 3-аас доошгүй хувь хэвлэмэл хувь хувь болон цахим хэлбэрээр хүргүүлнэ. Мөн 12 дугаар сарын 31-нд багтаан дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд батлуулах үүрэгтэй.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон 2012 онд шинэчлэн батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд (Төрийн мэдээлэл, 2012 оны 22 дугаар) аливаа төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрдэл хэсэг болох байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны төлөв байдлын үнэлгээгээр тодорхойлсон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар заасан.

Хуулийн дээрх шаардлагын дагуу төслийн үйл ажиллагаанаас тухайн нутгийн байгаль орчинд үзүүлэх гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг бууруулах арга хэмжээ, шаардагдах хөрөнгө зардлын хамт тодорхойлж, баримтлах хууль, дүрэм журам, стандартуудыг хамтатган байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулав.

3.1 БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ, ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗАРДЛЫН ХУРААНГУЙ

Нэхий таннери ХХК нь байгаль орчныг хамгаалахад шаардагдах төсөв хөрөнгийг жил бүр нарийвчлан тооцон, тухайн жилийн төсөвт багтаан, зохих хэлбэрээр зарцуулах үүрэгтэй. БОМТ-г хэрэгжүүлэх 2025 оны дундаж зардлыг **54,977,500 ₮** буюу тавин дөрвөн сая есөн зуун далан долоон мянган таван төгрөг байхаар тооцлоо. Төслийн БОМТ хэрэгжүүлэх 2025 онд дундаж зардлуудын хураангуйг доор харуулав.

Хүснэгт 3-1 БОМТ-г хэрэгжүүлэх зардал, 2025 он

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө		Нийт зардал, төг
1	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	6,100,000 ₮
		Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	100,000 ₮
		Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	13,537,500 ₮
		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	2,840,000 ₮
		Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	31,920,000 ₮
2	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	480,000 ₮
3	Талуудад БОМТ-ийн тайланг тайлагнах, хэлэлцүүлэх		-
Нийт зардал			54,977,500 ₮

3.1.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн үйл ажиллагаанаас гол болон болзошгүй сөрөг нөлөөлөлд өртөх орчноор буюу агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, хөрс болон ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах, усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, амьтны аймагт үзүүлж болзошгүй нөлөөллийг бууруулах арилгах зэрэг чиглэлүүдээр бүлэглэн авч үзсэнийг Хүснэгт 6-1-т бүрэн эхээр харуулав. Төсөл хэрэгжүүлэгч энэхүү БОХТ-г бүрэн хэрэгжүүлсэн нөхцөлд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, тэдгээрийг бууруулах, арилгах бүрэн боломжтой.

Хүснэгт 3-2. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9	
Агаар орчин									
1	Түүхий эд, бүтээгдэхүүнийг муудсан үнэр орчинд тархах	Түүхий эд хүлээн авах ажилчид маск зүүх, муудсан үйлдвэрийн шаардлага хангахгүй түүхий эдийг чанар шалгагч шалгаж ялган зориулалтын талбайд ангилан буцаана.	Түүхий эд буулгах талбай	-	-	-	Үйл ажиллагааны зардалд тусгах	Тогтмол	MNS ISO4227-2002 Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө” MNS 5885-2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага MNS 4990-2000 ХААЭА.
2		Үйлдвэрийн барилгад хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэх	Үйлдвэрийн дотор орчин	Гүйцэтгэлээр	2,000,000	1	2,000,000	1 удаа	Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага БНБД 41-01-11 “Халаалт, агаар сэлгэлт, кондиционерийн норм ба дүрэм” MNS6063-2010 Агаарын чанар, хот суурин газрын гадаад орчны агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ
3	Үйлдвэрийн дотоод агаарын чанар муудах, хэм нэмэгдэх	Үйлдвэрийн байранд дотоод орчныг сайжруулах, ажлын байрны үзлэг хийх, агааржуулалтыг тогтмол шалгах	Үйлдвэрийн дотор орчин	Гүйцэтгэлээр	-	1	Үйл ажиллагааны зардалд тусгах	Тогтмол	
4	Зам дээрх тээврийн хөдөлгөөнөөс агаарт тоосжилт үүсэх	Түүхий эд материал тээвэрлэх ирэх тээврийн хэрэгслийг үйлдвэрийн талбайд тогтсон маршрутаар зорчуулах	Замууд	-	-	-	Зардалгүй	Үйл ажиллагааны явцад	

Усан орчин									
1	Төслийн үйл ажиллагааны явцад ажилчдын унд ахуйд болон мод усалгаанд гүний ус ашигласнаар усны нөөц багасна	Үйлдвэрийн болон ахуйн ус дамжуулах шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн ашиглалтад тогтмол хяналт тавьж, гэмтсэн тохиолдолд засах	Үйлдвэрийн байр	Гүйцэтгэлээр	-	-	Үйл ажиллагааны зардалд тусгах	Тогтмол	MNS 4586-1998 , “Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага” MNS0899-1992 , “Унд, ахуйн зориулалттай усны төвлөрсөн хангамжийн эх булгийг сонгох журам, эрүүл ахуйн шаардлага” MNS0900-2018 , “ХБО. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900-2018 , “Ундны усны чанарын стандарт” Ус ашигласны төлбөр (Засгийн газрын 2005 оны 7-р тогтоол)
		Усны нөөцийн хомсдолоос сэргийлэхийн тулд эх үүсвэр дээр тоолуурыг заасан хугацаанд баталгаажуулж байх, төлбөрийн тогтмол төлөх	Үйлдвэрийн байр	Тоолуурын заалтаар	Усны төлбөрийн нэхэмжлэхийн дүнгээр		Сар бүр усны төлбөр төлөх		
	Цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа алдагдах холбогдох стандартад нийцэхгүй байх /MNS 6561 : 2015/	Үйлдвэрийн Цэвэрлэх байгууламжийн технологийн сайжруулалт хийх	Үйлдвэрийн цэвэрлэх байгууламж	Гүйцэтгэлээр	-	-	Хөрөнгө оруулалтын зардалд тусгах	Үйл ажиллагааны явцад	
Хөрсөн бүрхэвч, газрын гадарга									
1	Түүхий эд материал тээвэрлэн ирэх тээврийн хэрэгсэл олон салаа зам үүсгэснээр хөрсний эвдрэлд нэмэгдэх	Тээврийн хэрэгсэл нэвтрэх зөвшөөрөл болон зааварчилгааг өгч тогтсон маршрутын дагуу тээвэрлэлт хийлгэх. Зориулалтын талбайд тээврийн хэрэгслийг байршуулах	Замууд	-	-	-	-	Үйл ажиллагааны явцад	MNS 5916-2008 “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт”, MNS 5914:2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын

2	Түүхий эд материалыг зориулалтын бус талбайд буулгаснаар хөрс бохирдох	Түүхий эд /арьс, шир гэх мэт/ буулгах зориулалтын талбайг бэлтгэх	Түүхий эд буулгах талбай	Гүйцэтгэлээр	2,000,000	1	2,000,000	2 болон 3-р улиралд	нөхөн сэргээлт. Нэр томьёо, тодорхойлолт MNS 3297-1991 , “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм Хог хаягдлын тухай хууль MNS 5850-2019 , “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ”
3	Химийн бодисын зохисгүй хэрэглээнээс хөрс бохирдох	Химийн бодисын эрсдэлийн үнэлгээ, зөвлөмжийг чандлан баримтлах, ХАЛМ-ын дагуу хадгалж ашиглах	Үйлдвэрийн химийн бодис хадгалах агуулах	Гүйцэтгэлээр	-	-	-	Тогтмол	
Ургамлан нөмрөг, амьтны аймаг									
1	Ажилчдын хатуу шингэн хог хаягдлын улмаас хөрс бохирдох, ургамал талхлагдах,	Хог хаягдлыг ангилан ялгаж, Дархан-Уул аймгийн Дархан сумын нэгдсэн хогийн цэгт тогтмол зайлуулж байх. Хог хаягдлыг шатааж устгахыг хатуу хориглох.	Үйлдвэрийн талбай орчмын хөрс	Гүйцэтгэлээр	Зардал хог хаягдлын менежмент хэсэгт тусгагдсан		Үйл ажиллагааны туршид, сард нэг удаа (тогтмол)	Хог хаягдлын тухай хууль	
		Зориулалтын цэгээс гадагш элдэв хог хаягдал хаяхгүй, газрын төрх, хөрсийг эвдэхгүй, хөндөхгүй байх арга хэмжээг хэвшүүлэх, самбар пайз байрлуулах			Удирдлага зохион байгуулалтын арга хэмжээнд тусгагдсан	Үйл ажиллагааны туршид			

2	Хог хаягдлыг ил задгай хаясны улмаас хөрс, ургамал бохирдох үүнийг мал амьтан идэж хордох	Хог хаягдлын цэг, түүхий эд буулгах талбайг ариутгал халдваргүйжүүлэлт хийлгэх	Үйлдвэрийн талбай	Гүйцэтгэлээр	2,000,000	1	2,000,000	2-р улирал	Хог хаягдлын тухай хууль
Нийт		6,100,000 ₮ буюу зургаан сая нэг зуун мянган төгрөг							

3.1.2 Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний ажлын зардалд 100,000 ₮ буюу нэг зуун мянган төгрөг зарцуулах тооцоо гарсан болно.

Хүснэгт 3-3. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Хөрсний үржил шимтэй байдлыг хадгалах, агаарт тоосжилт бохирдол үүсэхээс урьдчилан сэргийлэх	Ногоон байгууламжийн талбайг арчилж тордох	Үйлдвэрийн ногоон байгууламжийн талбайд /4,129.75 м ² /	м ²	4,129.75	-	100,000	6,7,8,9-р саруудад	Байгаль орчныг хамгаалах тухай хууль Байгаль орчинд нөлөөлөх байдлыг тухай хууль Газрын тухай хууль MNS 5914:2008 Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт
Нийт	100,000 ₮ буюу нэг зуун мянган төгрөг							

3.1.3 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Төсөл хэрэгжих талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй. Гэвч үйлдвэрийн үйл ажиллагааны явцад соёлын өв олдсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ.

3.1.4 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 3-4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн зардал төг	Тоо хэмжээ	Нийт зардал (төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	2	3	5	6	7	8	9
Аянга цахилгаан	Үйлдвэрт ашиглагдаж байгаа цахилгаан тоног төхөөрөмжийн үзлэг хяналт	Үйлдвэр	-	1	Үйл ажиллагаа	2 удаа	MNS 4968:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага. MNS 4969:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуйн сургалтын зохион байгуулалт үндсэн дүрэм MNS 5390:2004 Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага.
Гал түймэр	Гал унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бүрдүүлж бэлэн байлгах, шаардлагатай тохиолдолд шинэчлэх. Галын булангийн үзлэгийг сар бүр хийх	Үйлдвэрийн талбай	-	12	Үйл ажиллагаа	Сар бүр	MNS ISO 13688:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага.
	Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийлгэх	Үйлдвэрийн барилга	2,000,000	1	2,000,000	1-р улирал	MNS ISO 13688:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага.
	Галын аюулгүй байдлын дүгнэлт шинэчлэх	Үйлдвэрийн барилга	-	1	Үйл ажиллагаа	1-р улирал	MNS ISO 13688:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа эрүүл ахуй. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага.
Үйлдвэрийн үйл ажиллагаанаас гэнэтийн болзошгүй байдлаар үйлдвэрт осол аваар гарах, тоног төхөөрөмж эвдрэх, ажилчид цахилгааны хүчдэлд цохиулах, түлэгдэх	Үйлдвэрийн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр тогтмол хангах, бүртгэл хийх	Үйлдвэрийн ажилчид	-	7	7 төрлийн хувцас	Үйл ажиллагааны туршид	MNS 4970:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Өргөх, зөөх ачааны массын дээд хэмжээ.
	ХАБЭА-н дүрэм журмыг таниулах сурталчлах, сургалт өгөх.		6,437,500	1	6,437,500	1 удаа	MNS 4992:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт бодисын ангилал ба аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага.
	Хөдөлмөрийн чадвар алдалт, Гэнэтийн ослын даатгал хийлгэх		2,700,000	1	2,700,000	1 удаа	MNS 5566:2005 Галын аюулаас хамгаалах. Аж ахуйн нэгж, байгууллага барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм.
Химийн бодисын асгаралт	Химийн бодис асгарах, алдагдах үед ашиглах асгаралтын иж бүрдлийн бүрэн бүтэн байдлыг шалгах	Үйлдвэрийн талбай	-	1	Үйл ажиллагаа	Тогтмол	

							MNS ISO 13688:2000
							Хамгаалалтын хувцас ерөнхий шаардлага
Химийн бодисын нөлөөнд өртөх	Химийн ослын үед ажиллах төлөвлөгөө батлуулах	Үйлдвэр	-	1	Үйл ажиллагааны зардал	2-р улирал	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам <i>Гурав.</i> Химийн хорт болон аюултай бодисыг хадгалахад тавих нэмэлт шаардлага
	Химийн бодистой зөв харьцах, хадгалах, ашиглах талаар агуулахын ажилчдад сургалт зохион байгуулах	Химийн бодистой харьцах ажилчид			ХАБЭА-н сургалтын зардалт тусгагдсан		
Химийн бодисын агуулахын аюулгүй байдал алдагдах	Химийн бодисын агуулахад тогтмол хугацааны давтамжтайгаар хяналт хийж, тэмдэглэл хөтлөх <ul style="list-style-type: none"> - Химийн бодис сав баглаа боодлын жилийн эцсийн тооллого. Мөн шаардлагатай тохиолдолд - Химийн бодисын агуулахын бүрэн бүтэн байдлыг шалгах, осол, асгарал шалгах - Ажилчдын хөдөлмөр хамгааллын хэрэгслийн бүрэн бүтэн байдал 	Агуулах	Гүйцэтгэл ээр	тогтмол	Зардалгүй	Улирал бүр	
НИЙТ ЗАРДАЛ					13,537,500₮ буюу арван гурван сая таван зуун гучин долоо мянган таван зуун төгрөг		

3.1.5 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Нэхий таннери ХХК нь үйл ажиллагаанаасаа гарч буй хог хаягдлын хэмжээг багасгах, аль болох бага хог хаягдал үүсгэх, түүнийг дахин ашиглах болон дахин боловсруулах замаар гарсан хог хаягдлын хэмжээг бууруулах, үлдсэн хог хаягдлыг хүрээлэн буй орчинд аюулгүй байдлаар устгах зарчмыг баримтлан ажиллана.

Хог хаягдлын сөрөг нөлөөлөл болон түүний хэмжээг бууруулахад 2025 онд 2,840,000 ₮ буюу хоёр сая найман зуун дөчин мянган төгрөг зарцуулахаар төлөвлөсөн.

Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга /2017/ болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны А/443 дугаар тушаалаар батлагдсан “Энгийн хог хаягдлыг ангилал, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”-д тус тус зааснаар төсөл хэрэгжүүлэгч Нэхий таннери ХХК нь дараах үүргийг хүлээнэ. Үүнд:

- ❖ Хог хаягдлаа эрх бүхий байгууллагаар “Хог ачиж, тээвэрлүүлэх гэрээ”-ний дагуу ангиллын төрөл тус бүрээр нэгдсэн хогийн цэг рүү ачуулах
- ❖ Үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилан ялгах, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах эрх бүхий байгууллагад гэрээ байгуулан шилжүүлэх, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх
- ❖ Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх
- ❖ Байгууллагын ажилтнуудад хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх;
- ❖ Орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар, зам талбайн хог хаягдал, шарилж, лууль зэрэг ургамал, цас мөсийг тогтмол цэвэрлэх;
- ❖ Бүх нийтийн их цэвэрлэгээнд ажилтан, албан хаагчдыг хамруулах, холбогдох зардлыг гаргаж цэвэрлэгээний багаж хэрэгслээр хангах;
- ❖ Бүх нийтийн их цэвэрлэгээний өдрүүдэд орон нутгийн захиргаанаас зураглалаар хариуцуулсан нийтийн эдэлбэр газар, гудамж, зам, талбайн хог хаягдлыг цэвэрлэж, холбогдох байгууллагад хүлээлгэж өгөх
- ❖ Энгийн хог хаягдлыг хамгийн багадаа 3 төрлөөр буюу 1. Дахин боловсруулах боломжтой 2. Дахин боловсруулах боломжгүй 3. Хүнсний органик хог хаягдал гэж төрөлжүүлэн эх үүсвэр дээр ангилан ялгах;
- ❖ Картон цааснаас бусад төрлийн ангилсан хаягдлыг зориулалтын уутанд хийж, уутны амыг боож битүүмжлэн шаардлага хангасан хогийн сав, бункерт байршуулан хадгалах ба хог ачиж цуглуулах хуваарийн дагуу ангиллын төрөл тус бүрээр хог тээврийн авто машинд ачуулах;
- ❖ Энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах төрлийг хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрлэлтэй уялдуулан төсөл хэрэгжүүлэгч өөрийн санаачилгаар нэмэгдүүлэх
- ❖ 0,75 м³-с дээш эзлэхүүнтэй овор хэмжээ их энгийн болон барилгын хог хаягдлыг Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3-д заасны дагуу нэмэлт үйлчилгээний хөлс төлж эрх бүхий мэргэжлийн байгууллагаар тээвэрлүүлэх

Хүснэгт 3-5 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
1	2	3	4	5	6	7	8	9		
1.	Ахуйн	Хог хаягдлын нэгдсэн сав орчимд тогтмол ариутгал, цэвэрлэгээ хийх, сар бүр тогтмол зөөвөрлүүлэх	Хог хаягдал хадгалах түр цэг	удаа	150,000	12	1,800,000	2025 онд тогтмол сард нэг удаа	<p style="text-align: center;">Хог хаягдлын тухай хууль; Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/349 дугаар тушаалын хавсралт. Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл; MNS 5344 : 2011 Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага; Засгийн газрын 2018 оны 116 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт. Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам</p>	
		Үйлдвэрийн талбайд нэгдсэн байдлаар цэвэрлэгээ хийх	Төслийн талбай орчимд	удаа	-	1	Үйл ажиллагааны зардал	2025 онд 1 удаа		
2.	Үйлдвэрийн	Цэвэрлэх байгууламжийн хаягдал ус болон лагыг тогтмол холбогдох байгууллагад нийлүүлэх	Үйлдвэрийн талбай	удаа	Үйл ажиллагааны зардал	тогтмол	Үйл ажиллагааны зардал	Тогтмол		
		Түүхий эдийг зориулалтын бус талбайд буулгахыг хориглох, буулгасан талбайд тогтмол цэвэрлэх	Хог хаягдал хадгалах түр цэг	удаа	-	-	Үйл ажиллагааны зардал	Түүхий эдийн хаягдал үүсэх бүрт		
		Үйлдвэрлэлийн процесст үүсэх ус ноос, ширний хаягдлыг дахин боловсруулж бүтээгдэхүүн болгох судалгаа туршилт хийх	Үйлдвэрлэл	удаа	Үйл ажиллагааны зардал		2025 оны туршид			
3	Аюултай	Үйл ажиллагаанаас гарч буй химийн бодисын сав баглаа боодлыг журмын дагуу түр хадгалан, тусгай зөвшөөрөл бүхий байгууллагад өгөх	Үйлдвэрийн талбай	Удаа	920,000	2	1,040,000	2025 онд Хуулийн хугацаанд		
Нийт			2,840,000 ₮ буюу хоёр сая найман зуун дөчин мянган төгрөг							

3.1.6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Энэхүү Дархан арьс шир боловсруулах цогцолбор үйлдвэр төслийг хэрэгжүүлэх явцад гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор тогтмол хянаж байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь, баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.

БОХШХ нь байгаль орчин, нийгэм эдийн засгийн үнэт зүйлсийг хамгаалах, түүнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагаа нь ямар үр дүнтэй байгааг илтгэх үндсэн баримт бичиг болно. Цаашдаа БОМТ-г улам боловсронгуй болгох байгаль орчин, нийгэм эдийн засгийн болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг илүү нарийвчлан тогтоох боломжтой болно. ОХШХ-ийг жил бүр шинэчлэн боловсруулж тухайн оныхоо эхэнд БОНХАЖЯ-аар батлуулж, оны эцэст тэдгээрийн биелэлтийг мөн БОНХАЖЯ-нд тайлагнана. Хяналт шинжилгээний дээж, сорьцыг МУ-ын болон гадаадын итгэмжлэгдсэн лабораториудад батлагдсан аргазүй, стандартын дагуу шинжлүүлнэ. Төсөл хэрэгжүүлэгч нь ОХШХ-г хэрэгжүүлэхдээ хяналт шинжилгээний үр дүнг хянах үйл ажиллагааг хөндлөнгийн мэргэжлийн байгууллагуудаар, орон нутгийн иргэдийн хөндлөнгийн хяналтын доор гүйцэтгүүлэх зэргээр оролцогч талуудын хяналтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй юм. Төслийн үйл ажиллагааны явцад төлөвлөгдөөгүй судалгаа, хяналт шинжилгээний ажлууд гарч ирэхийг үгүйсгэх аргагүй юм. Төслийн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт зардал, түүний хуваарилалтыг жил бүр шинэчлэн тооцож байх шаардлагатай болно.

2021 оны “Эко натур” ХХК-ийн боловсруулсан БОННУ-ний нэмэлт тодотголын тайланд тусгагдсан ус чанарын хяналт шинжилгээг үндны усанд хийхээр төлөвлөсөн ч усны хэрэглээг төвийн шугамаас хангадаг учир үйлдвэрийн цэвэрлэх байгууламж бохир усны хяналт шинжилгээг хийхээр төлөвлөлөө.

Хүснэгт 3-6 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн өртөг	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт ба арга, аргачлал
1	2	3	4	5	6	7	8
Агаарын чанар							
Агаар дахь органик биш нэгдэл - NO ₂ , SO ₂ - Нийт тоос	Салхины зонхилох чиглэл болон эх үүсвэрийн байршил дахь агаар бохирдуулагчийн тархалтыг гаргахад төлөөлөх чадвартай 2 цэгт	Жилд 2 удаа	2	80,000	160,000	-	MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. MNS 5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага. MNS 0017-2-3-16:1988 Хот суурин газрын агаарын чанарыг хянах журам. MNS
Хөрсөн бүрхэвч							

“Нэхий таннери” ХХК-ийн хэрэгжүүлж буй “Дархан арьс шир боловсруулах цогцолбор үйлдвэр” төслийн
2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хөрсний ерөнхий хими, хүнд металл	Төслийн талбай орчимд 2 цэгт	Жилд 2 удаа 2 цэгт	2	80,000	160,000	-	MNS 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам; MNS 3298-1991 Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд; MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ;
Усны чанар							
MNS 6561 : 2024 Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усны үзүүлэлтүүд	Цэвэрлэх байгууламжийн оролт, гаралтын ус	Жилд 2 удаа 2 цэгт	2	80,000	160,000	-	MNS3936:1986 Ундны ус болон үйлдвэрийн ус-Тухайн талбарт нь шинжилгээ хийх MNS3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-Химийн шинжилгээ хийх-дээж авах
Орчны хяналт шинжилгээ хийхэд зарцуулагдах урьдчилсан байдлаар тооцсон зардал						480,000₮ буюу дөрвөн зуун наян мянган төгрөг	

3.1.7 Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Төслийн 2025 оны явцад удирдлага зохион байгуулалтын хүрээнд 31,920,000₮ буюу гучин нэгэн сая есөн зуун хорин мянган төгрөг зарцуулах төлөвлөгөөг гаргалаа.

Хүснэгт 3-7 Удирдлага зохион байгуулалтын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв , мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан
			2025 он			
			1-4 Сар	5-8 Сар	9-12 Сар	
1	Үйлдвэрлэлийн хэсгийн дотоод орчинг сайжруулах	20,000.0	1-3-р саруудад	-	-	Удирдлага, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн
2	Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэлийн дагуу хог хаягдлын төрөл, кодыг тогтоон ялгаж бүртгэл хөтлөх	Үйл ажиллагааны зардалд тусгах	Жилийн түрш			Удирдлага, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн
3	Хог хаягдлыг ангилан ялгаж, гэрээт ААН (ачиж тээвэрлэх эрх бүхий байгууллагаар)-ээр төслийн талбайгаас тогтмол зөөвөрлүүлэх	Үйл ажиллагааны зардалд тусгах	Жилийн түрш			Удирдлага, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн
4	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, орчны хяналт шинжилгээг хийх. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг холбогдох байгууллагаар дүгнүүлэх	Үйл ажиллагааны зардалд тусгах			11-р сар	Удирдлага, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн
5	Хаягдал усны дүгнэлт гаргуулах	Үйл ажиллагааны зардалд тусгах		5-8-р сар		Удирдлага, байгаль орчны мэргэжилтэн
6	Тэрбум мод хөтөлбөрийн хүрээнд орон нутагтай хамтран ажиллаж, орон нутгаас санал болгосон талбайд мод тарих, дэмжлэг үзүүлэх	Үйл ажиллагааны зардалд тусгах	Орон нутгаас санаачилсан хугацаанд			Удирдлага, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн

7	Үйлдвэрийн барилга байгууламжийн дэд бүтцийн /Дулаан, уур, ус, цахилгаан/ холбогдох гэрээг холбогдох байгууллагуудтай сунгах, төлбөрийг тогтмол төлөх	Үйл ажиллагааны зардалд тусгах			Гэрээний хугацаа дуусахад	Удирдлага, байгаль орчны мэргэжилтэн
8	Үйлдвэрийн дулаан, ус хангах шугам хоолойг засварлах, шинэчлэх	4,500.0				Удирдлага, инженер
9	Үйлдвэрийн ажилчдад эрүүл мэндийн багц үзлэг	7,320.0	-	5-р сар	-	Удирдлага, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн
10	Үйлдвэрийн тасгуудад байрлах эмийн сангийн бүртгэлийн хийж, шаардлага эм, хэрэгслийг нэмж байршуулах	100.0	2-р сар	-	-	Удирдлага, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтэн
Нийт зардал		31,920,000₮ буюу гучин нэгэн сая есөн зуун хорин мянган төгрөг				

3.1.8 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Нэхий таннери ХХК нь жил бүр тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар тайланг БОАЖЯ болон Дархан-Уул аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлнэ. Мөн БОМТ-ний хэрэгжилтийн талаар байгаль орчны хяналтын улсын байцаагч, Засаг дарга болон бусад оролцогч талуудад танилцуулгыг жил тутам хийнэ.

Хүснэгт 3-8. БОМТ-ний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хугацааны тов	Тайлагнах зардал, сая төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7
Төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин аялал жуулчлалын яам/	БОМТ-ний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.	Тухайн жил төлөвлөсөн ажлаа хэрхэн гүйцэтгэсэн түүний үр дүнг өгүүлбэрээр дэлгэрэнгүй илэрхийлсэн текст байна. Тухайн текст нь ажлын гүйцэтгэл, үр дүнтэй холбоотой фото зургаар баталгаажсан байна	2025 оны 12 дугаар сарын 30-наас өмнө	Үйл ажиллагааны зардалд тусгах	Байгаль орчны мэргэжилтэн	Цахим
Дархан-Уул аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар	БОМТ-ний хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны БОМТ-ний төсөлтэй хамтатган ерөнхий үнэлгээ хийсэн байгууллагад хүргүүлнэ.		2025 оны 11 дугаар сарын 01-наас өмнө			Дархан-Уул аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар
Дархан сумын ЗДТГ-т	БОМТ-ний хэрэгжилтийн тайланг иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулж танилцуулах		2025 оны 11 дүгээр сарын 01-нээс өмнө			Дархан сумын ЗДТГ-т